



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 8/175.

Улаанбаатар хот

“Эмийн мэдээлэл” товхимлын редакцын
зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журам батлах тухай” А/295 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эм, эмийн түүхий эд, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн төлбөр, зардлын жишиг, зарцуулах журам”-ын 2.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Эмийн мэдээлэл” товхимлын редакцын зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Редакцын зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Товхимлыг эмхэтгэн бэлтгэж, улсын хэмжээнд хүртээмжтэй түгээх ажлыг зохион байгуулахыг Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар (П.Цэцгээ)-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/88 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт
зохицуулалтын газрын даргын 2022 оны
..... дугаар сарын.....-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ” ТОВХИМЛЫН РЕДАКЦЫН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ерөнхий редактор

(Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын дарга)

Нарийн бичиг

(Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмийн
аюулгүй байдлын тандалт,
судалгааны газрын Эмийн зохистой
хэрэглээний асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Гишүүд

(Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмийн
аюулгүй байдлын тандалт,
судалгааны газрын дарга)

(Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмийн
аюулгүй байдлын тандалт,
судалгааны газрын Ахлах
мэргэжилтэн)

(Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын Эмийн
аюулгүй байдлын тандалт,
судалгааны газрын Нянгийн эсрэг
эмийн зохистой хэрэглээний
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Х.Алтайсайхан

АУ-ны доктор, профессор,
АШУҮИС-ийн Анагаах Ухааны
сургуулийн багш
(зөвшилцсөнөөр)

М.Уранчимэг

(ШАУИС-ын Эмзүйн сургуулийн
захирал, Эмзүйн ухааны доктор,
дэд профессор)
(зөвшилцсөнөөр)

М.Эрдэнэтуяа

АУ-ны доктор /Ph.D/, дэд
профессор, АШУҮИС-ийн Эм зүйн
сургуулийн багш
(зөвшилцсөнөөр)

Д.Нарантунгалаг	АУ-ны доктор /Ph.D/, АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн Эм судлалын тэнхимийн багш (зөвшилцсөнөөр)
С.Пүрэвсүрэн	АУ-ны доктор /Ph.D/, дэд профессор, АШУҮИС-ийн Эм судлалын тэнхимийн эрхлэгч (зөвшилцсөнөөр)
Н.Халиун	АУ-ны доктор /Ph.D/, АШУҮИС-ийн Био-Анагаахын сургуулийн Эм судлалын тэнхимийн багш (зөвшилцсөнөөр)
Ш.Энхтуяа	(АУ-ны магистр, клиникийн профессор) (зөвшилцсөнөөр)
Б.Ганзориг	Шинэ Анагаах Ухаан Дээд сургуулийн сургалтын албаны мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)
З.Зузаан	Эм, зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)

--ooOOoo--

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт
зохицуулалтын газрын даргын 2022 оны
..... дугаар сарын-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Эмийн мэдээлэл" товхимлын редакцын зөвлөл (цаашид Зөвлөл гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зөвлөл нь Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, Антибиотикийн хэрэглээг зохистой болгож, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх стратегийг хэрэгжүүлэх, эм зүйн салбарын ил тод байдлыг хангаж, эмийн зохицуулалтын үйл ажиллагаанд мөрдөх ёс зүйг дээшлүүлэх. арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэсэн мэдээллийг товхимолд нийтлэх ажлыг Эм эмнэлгийн хэрэгслийн тухай, Зар сурталчилгааны тухай, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн хүрээнд зохион байгуулна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1 Зөвлөл нь товхимлын ерөнхий редактор, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын тушаалаар батална.

2.2 Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд хэвлэлийн компанитай гэрээ байгуулан ажиллаж товхимлын загвар, хэв маягийг мэргэжлийн өндөр түвшинд гаргах ажлыг зохион байгуулна.

2.3 Товхимлыг жилд 1-2 удаа эрхлэн гаргах бөгөөд хэвлэлтээс гарсны дараа түгээх ажлыг Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар хариуцна.

2.4 Товхимол нь идэвхтэн бичигчтэй байх бөгөөд нарийн бичгийн дарга нийтлэлийн төлөвлөгөөг урьдчилан зарлах, материалыг хүлээн авах, хянуулах, нийтлэхэд бэлтгэх, хэвлэлтэд хүлээлгэн өгөх, түгээх ажлыг хариуцлагатай гүйцэтгэнэ.

2.5 Товхимлын редакторыг хагас жил тутам зөвлөлийн гишүүд дундаас олонхын саналаар сонгоно.

Гурав. Зөвлөлийн эрх үүрэг

1.1 Зөвлөл идэвхтэн бичигчдээс хүлээн авсан нийтлэлийн утга санааг алдагдуулахгүй хураангуйлах, алдааг засуулахаар буцаах, төлөвлөсөн хугацаанд материал ирүүлэхийг шаардах эрхтэй.

1.2 Зөвлөл нь нийтлэлийн агуулга, багтаамж, хэв маягийг хагас, бүтэн жилээр төлөвлөж ажиллана.

1.3 Зөвлөл нь эм зүйн салбарын ил тод байдал, эм зүйн сайн засаглалыг бэхжүүлэх арга хэмжээний хүрээнд хийгдсэн үйл ажиллагаа, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмнэлгийн болон эмийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч, иргэдэд эмийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд үнэн зөв, бодит мэдээллээр хангах үүрэгтэй.

1.4 Товхимлыг төлөвлөсөн хугацаанд багтааж гаргахад бүх гишүүд идэвх санаачилгатай ажиллах үүрэгтэй.

1.5 Зөвлөлийн гишүүд товхимлын тодорхой нэг буланг хариуцаж, нийтлэлийг бэлтгэхэд оролцох үүрэгтэй.

1.6 Зөвлөл нь 4 болон 10 дугаар сарын сүүлийн 10 хоногт хуралдаж тухайн хагас жилд гарах товхимлын нийтлэлийн агуулгыг батална.

Дөрөв. Мэдээ нийтлэлд тавих ерөнхий шаардлага

4.1 Эмийн мэдээлэл товхимлыг хэвлэн нийтлэхэд тавигдах техникийн шаардлага

Нэр: Эмийн мэдээлэл товхимол

Дотор тал: Цаасны хэмжээ А4, 105 гр шохойтой цаас

Өнгө: (4+4) (зураг график, өнгөтөөр)

Хуудасны тоо: 100-120 нүүр

Хавтас: А4, 250 гр шохойтой цаас, өнгө (4+4)

Тоо хэмжээ: Хагас жил тутам 1000ш

4.2 Идэвхтэн бичигчдээс ирүүлсэн нийтлэл нь хянаж засварлахад ойлгомжтой, зураг график, хүснэгтийн дор эх сурвалж, тайлбарыг бичиж, ашигласан материал, ном зүйн жагсаалтыг хавсаргасан байна.

4.3 Зохиогчийн овог, нэр, эрдмийн цол, эрхэлж буй ажил, харилцах утсыг тодорхой бичсэн байна.

4.4 Мэдээ нийтлэлийн үнэн бодит байдлыг зохиогч бүрэн хариуцна.

4.5 Мэдээ нийтлэлийг А4 цаасны 4-өөс илүүгүй хуудсанд багтаан Arial 12. мөр хоорондын зай нь 1 хэмжээгээр бэлтгэж, цаасаар болон файлаар ирүүлнэ.

Тав. Ажлын хөлс

5.1 гишүүн идэвхтэнд дараах жишгийг баримтлан эмийн бүртгэлийн төлбөрөөс ажлын хөлс олгоно.

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Ажлын хөлсний хэмжээ
1.	Зөвлөлийн гишүүдийн ажлын хөлс	Цаг	20,000 төгрөг
2.	Бичсэн нийтлэлийн ажлын хөлс	А4 хэмжээтэй стандарт хуудасны тоо	40,000 төгрөг
3.	Редакторын ажлын хөлс	1 дугаар	200,000 төгрөг

--ooOOoo--